



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар АН96

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Дэлгэрхаан" уулын тахилга, Цагаан адууны баяр, "Дархад хурд-6" өв соёлын наадам, "Хүчээ нэгтгэе" 1000 залуучуудын чуулга уулзалтын арга хэмжээнд ашигласан тоног төхөөрөмжийн түрээсийн зардалд 4000000 (Дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 4000000 (Дөрвөн сая) төгрөгийг "Хамтын оролцоо-Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийн төсвөөс зарцуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД